



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

26 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /95/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn
Аудитор: Б.Бямбатогтох
Утас: 70350757 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 68
танай _____ -ны № _____ -г

ОРХОН АЙМГИЙН 26 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Э.СҮНЖИДМАА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 26 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

26 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>103,969,540.20</u>	<u>101,921,475.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	1,440,901.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,440,901.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	102,528,639.20	101,921,475.00
351	Түүхий эд материал	98,732,959.20	100,980,900.00
35110	Тусгай зориулалттай материал	96,985,060.00	100,012,150.00
35130	Эм боох материал	1,747,899.20	968,750.00
354	Хангамжийн материал	3,795,680.00	940,575.00
35410	Бичиг хэргийн материал	697,600.00	329,840.00
35420	Аж ахуйн материал	1,952,950.00	502,900.00
35450	Барилгын засварын материал	92,000.00	-
35460	Хүнсний материал	1,053,130.00	107,835.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,750,565,492.76</u>	<u>2,665,674,294.61</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,750,565,492.76	2,665,674,294.61
392	Биет хөрөнгө	2,392,021,742.70	2,307,268,044.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,402,540,143.00	2,402,540,143.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(98,974,714.51)	(168,839,218.87)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	46,731,110.70	46,731,110.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(15,618,492.81)	(23,173,411.02)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,291,883.40	69,864,311.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,948,187.08)	(19,854,891.20)
393	Биет бус хөрөнгө	358,543,750.06	358,406,250.10
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(206,249.94)	(343,749.90)
39303	Бусад биет бус хөрөнгө	358,200,000.00	358,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,854,535,032.96</u>	<u>2,767,595,769.61</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,496,335,032.96</u>	<u>2,409,395,769.61</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,496,335,032.96	2,409,395,769.61
512	Хуримтлагдсан үр дүн	2,496,335,032.96	2,409,395,769.61
51210	Өмнөх үеийн үр дүн	2,496,335,032.96	2,496,335,032.96
51220	Тайлант үеийн үр дүн	-	(86,939,263.35)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,496,335,032.96</u>	<u>2,409,395,769.61</u>



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	624,468,339.10	572,813,828.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,913,839.10	646,028.50
120	Нийтлэг татварын бус орлого	10,913,839.10	646,028.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,665,339.10	646,028.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,505,800.00	646,028.50
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		572,428.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		73,600.00
120009	Бусад орлого	5,248,500.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	613,554,500.00	572,167,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	546,784,900.00	515,273,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	546,784,900.00	515,273,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,065,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	285,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	280,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,829,000.00	55,829,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,829,000.00	55,829,000.00
1330	Төсвийн захирагчдаас	10,940,600.00	-
133003	Хөрөнгийн	10,940,600.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	633,363,245.53	659,753,091.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	633,363,245.53	659,753,091.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	602,415,242.63	625,207,109.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	438,899,565.23	434,271,913.12
210101	Үндсэн цалин	306,036,806.20	276,199,149.00
210102	Нэмэгдэл	90,977,009.03	117,980,545.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,378,800.00	137,637.12
210104	Урамшуулал	40,506,950.00	39,954,582.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,937,180.08	57,149,932.03
210201	Тэтгэврийн даатгал	40,070,971.97	40,137,438.93
210202	Тэтгэмжийн даатгал	4,173,070.04	4,376,626.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,955,443.43	3,467,383.92
210204	Ажилгүйдлийн даатгал	758,809.53	798,221.90
210205	Эрүүл мэндийн даатгал	7,978,885.11	8,370,260.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,607,255.69	20,001,873.02



210301	Гэрэл, цахилгаан	6,665,726.54	5,442,887.81
210302	Түлш, халаалт	7,750,627.70	7,850,137.52
210303	Цэвэр, бохир ус	10,190,901.45	6,708,847.69
2104	Хангамж, бараа материалын зардал	8,558,350.00	3,472,480.00
210401	Бичиг хэрэг	334,500.00	244,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	156,000.00	127,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,542,700.00	1,391,470.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,243,400.00	1,409,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	281,750.00	299,150.00
2105	Нормативт зардал	33,506,904.80	21,451,074.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	479,800.00	506,479.20
210502	Хоол, хүнс	33,027,104.80	20,905,595.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	39,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,442,200.00	1,807,500.00
210604	Урсгал засвар	1,442,200.00	1,807,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,455,786.83	87,052,336.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	410,000.00	375,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,782,270.00	1,213,710.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,263,516.83	85,463,626.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,948,002.90	34,545,982.83
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	28,937,544.31	34,111,626.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,937,544.31	34,111,626.98
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,010,458.59	434,355.85
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,010,458.59	434,355.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(8,894,906.43)	(86,939,263.35)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(8,894,906.43)	(86,939,263.35)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	2,515,984,239.39	2,515,984,239.39
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	2,515,984,239.39	2,515,984,239.39
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-



C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	358,200,000.00	-	358,200,000.00
C07	Тайлант үеийн үр дүн	-	(19,649,206.43)	(19,649,206.43)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	358,200,000.00	2,496,335,032.96	2,854,535,032.96
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	358,200,000.00	2,496,335,032.96	2,854,535,032.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	358,200,000.00	2,496,335,032.96	2,854,535,032.96
D08	Тайлант үеийн үр дүн	-	(86,939,263.35)	(86,939,263.35)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	358,200,000.00	2,409,395,769.61	2,767,595,769.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>610,028,309.00</u>	<u>575,205,159.00</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	610,028,309.00	575,205,159.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	546,784,900.00	515,273,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	546,784,900.00	515,273,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,065,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	285,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	280,000.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,829,000.00	55,829,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,829,000.00	55,829,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7,414,409.00	3,037,359.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	7,414,409.00	3,037,359.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>609,628,309.00</u>	<u>575,205,159.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	609,628,309.00	575,205,159.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	571,265,897.10	537,621,817.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	440,715,900.00	432,771,011.20
210101	Үндсэн цалин	306,036,806.20	264,051,339.20
210102	Нэмэгдэл	97,491,224.49	130,876,436.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,378,800.00	1,740,000.00
210104	Урамшуулал	35,809,069.31	36,103,236.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,906,161.21	57,209,932.95
210201	Тэтгэврийн даатгал	40,070,980.97	40,197,440.35
210202	Тэтгэмжийн даатгал	4,173,070.04	4,376,626.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,955,443.43	3,467,383.92
210204	Ажилгүйдлийн даатгал	758,809.53	798,221.90



210205	Эрүүл мэндийн даатгал	7,947,857.24	8,370,260.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,607,255.69	20,001,873.02
210301	Гэрэл, цахилгаан	4,217,377.74	5,442,887.81
210302	Түлш, халаалт	9,457,113.87	7,850,137.52
210303	Цэвэр, бохир ус	10,932,764.08	6,708,847.69
2104	Хангамж, бараа материалын зардал	9,284,200.00	1,741,000.00
210401	Бичиг хэрэг	193,400.00	437,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	156,000.00	127,800.00
210404	Ном, хэвлэл	121,000.00	98,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,465,600.00	792,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	348,200.00	284,100.00
2105	Нормативт зардал	34,049,510.20	21,032,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	206,199.20	375,700.00
210502	Хоол, хүнс	32,794,311.00	19,960,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,049,000.00	696,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,884,200.00	1,715,500.00
210604	Урсгал засвар	1,884,200.00	1,715,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,810,670.00	3,149,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	410,000.00	375,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,400,670.00	2,774,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,362,411.90	37,583,341.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,414,409.00	3,037,359.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	7,414,409.00	3,037,359.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	28,937,544.31	34,111,626.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,937,544.31	34,111,626.98
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,010,458.59	434,355.85
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,010,458.59	434,355.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	400,000.00	=
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	400,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	400,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	400,000.00	-
223001	Бусад хөрөнгө	400,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(400,000.00)	=
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	628,889,389.00	571,665,897.10	571,102,800.00	536,556,817.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	628,889,389.00	571,265,897.10	571,102,800.00	536,556,817.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	628,889,389.00	571,265,897.10	571,102,800.00	536,556,817.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	440,715,900.00	440,715,900.00	432,771,300.00	432,771,011.20
210101	Үндсэн цалин	302,909,900.00	306,036,806.20	256,556,300.00	264,051,339.20
210102	Нэмэгдэл	98,423,700.00	97,491,224.49	134,590,500.00	130,876,436.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,360,000.00	1,378,800.00	4,018,200.00	1,740,000.00
210104	Урамшуулал	36,022,300.00	35,809,069.31	37,606,300.00	36,103,236.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,906,400.00	55,906,161.21	57,210,100.00	57,209,932.95
210201	Тэтгэврийн даатгал	38,324,900.00	40,070,980.97	39,799,500.00	40,197,440.35
210202	Тэтгэмжийн даатгал	4,395,400.00	4,173,070.04	4,352,700.00	4,376,626.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,516,300.00	2,955,443.43	3,482,100.00	3,467,383.92
210204	Ажилгүйдлийн даатгал	879,100.00	758,809.53	870,500.00	798,221.90
210205	Эрүүл мэндийн даатгал	8,790,700.00	7,947,857.24	8,705,300.00	8,370,260.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,544,800.00	24,607,255.69	53,544,800.00	20,001,873.02
210301	Гэрэл, цахилгаан	12,764,000.00	4,217,377.74	12,764,000.00	5,442,887.81
210302	Түлш, халаалт	29,582,300.00	9,457,113.87	29,582,300.00	7,850,137.52
210303	Цэвэр, бохир ус	11,198,500.00	10,932,764.08	11,198,500.00	6,708,847.69
2104	Хангамж, бараа материалын зардал	10,875,200.00	9,284,200.00	961,000.00	961,000.00
210401	Бичиг хэрэг	193,400.00	193,400.00	157,800.00	157,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	156,700.00	156,000.00	127,800.00	127,800.00
210404	Ном, хэвлэл	121,000.00	121,000.00	98,700.00	98,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,055,900.00	8,465,600.00	292,600.00	292,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	348,200.00	348,200.00	284,100.00	284,100.00
2105	Нормативт зардал	60,343,689.00	34,049,510.20	20,922,400.00	20,747,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	206,200.00	206,199.20	90,700.00	90,700.00
210502	Хоол, хүнс	59,069,889.00	32,794,311.00	19,960,600.00	19,960,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,067,600.00	1,049,000.00	871,100.00	696,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,284,200.00	1,884,200.00	2,284,200.00	1,715,500.00
210604	Урсгал засвар	2,284,200.00	1,884,200.00	2,284,200.00	1,715,500.00
2107	Томилолт, зочны зардал	197,700.00	-	134,300.00	-
210702	Дотоод албан томилолт	197,700.00		134,300.00	-



2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,000.00	1,008,000.00	-	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,013,500.00	3,810,670.00	3,274,700.00	3,149,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	612,800.00	410,000.00	500,000.00	375,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,400,700.00	3,400,670.00	2,774,700.00	2,774,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	400,000.00	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	400,000.00	-	-
223001	Бусад хөрөнгө		400,000.00		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	602,613,900.00	602,073,900.00	571,102,800.00	571,102,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	546,784,900.00	546,784,900.00	515,273,800.00	515,273,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	546,784,900.00	546,784,900.00	515,273,800.00	515,273,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	55,829,000.00	55,289,000.00	55,829,000.00	55,829,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	55,829,000.00	55,289,000.00	55,829,000.00	55,829,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42.00	42.00	42.00	42.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00	29.00	29.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	12.00	12.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	42.00	42.00	42.00	42.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	27.00	27.00	27.00	27.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15.00	15.00	15.00	15.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,065,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,065,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,065,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	780,000.00
210401	Бичиг хэрэг	-	280,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	500,000.00
2105	Нормативт зардал	-	285,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	285,000.00



II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,065,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,065,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	285,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	280,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу 26 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Бямбатогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

26 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

26 дугаар цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх байгууллага юм.

Хүүхдийн сурах үйлийг дэмжиж эцэг эх хамтын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил, төлөвшилд ахиц гаргах, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилготой ба дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ.

- Хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх, бэлэн байдлыг хангаж, сургалтыг танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулах,



- “Хөдөлгөөн-эрүүл бие” дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлэх,
- Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх,
- Цэцэрлэгийн өөрийн үнэлгээг хамтын оролцоотойгоор хийж, дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж буй дүрэм журмыг хэрэгжүүлэн ажиллах,

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТХууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

26 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 572,167.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,566.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,424.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

26 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 86,939.3 мянган төгрөгөөр буюу 3.05 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.



Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Бараа материал	102,528.6	101,921.5	(607.1)
Үндсэн хөрөнгө	2,750,565.5	2,665,674.3	(84,891.2)
Нийт хөрөнгө	2,854,535.0	2,767,595.8	(86,939.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,854,535.0	2,767,595.8	(86,939.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,854,535.0	2,767,595.8	(86,939.2)

Бараа материалын данс 101,921.5 мянган төгрөг болж 607.1 мянган төгрөгөөр буурсан нь эхний үлдэгдэлтэй бараа материалыг зарлагдаж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,665,674.3 мянган төгрөг болж 84,891.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд томоохон хөрөнгө бүртгээгүй, 212,211.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тооцсонтой холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр дансны үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,767,595.8 мянган төгрөг болж 86,939.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

26 дугаар цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 51,654.5 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар буурсан, нийт зардал өмнөх оноос 26,389.8 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

26 дугаар цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 761,356.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 761,356.3 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 120,029.0 мянган төгрөгөөр бууруулан 641,327.3 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсөвт 1 удаа тодотгол хийж 70,224.5 мянган төгрөгөөр бууруулж, 571,102.8 мянган төгрөгөөр баталжээ. Тодотголоор нормативт зардлыг бууруулжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 515,273.8 мянган төгрөгийг улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 55,829.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 536,556.8 мянган төгрөгийг зарцуулж, 34,545.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.



Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 536,556.8 мянган төгрөг буюу 93.9 хувьтай байгаа байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 33,542.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 568.7 мянган төгрөг, томилолтын зардлыг 134.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 125.0 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн БСУГ-аас 2800.0 мянган төгрөгийн бичиг хэрэг, 500.0 мянган төгрөгийн хог хаягдал зайлуулах, 285.0 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

26 дугаар цэцэрлэг нь 2021 онд нийт 584,037.7 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 584,037.7 мянган төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлсэн байна.



3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин ажлын хувцас худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.4 дэх заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 215.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4,312.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,440.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	1	215.5	1	215.5			
Албан шаардлага	1	4.312.8	1	4.312.8			
Зөвлөмж	2	1,440.9	2	1,440.9			
Нийт дүн	4	5,969.2	4	5,969.2			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,665.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 719.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 570.6 мянган төгрөгт 1 албан шаардлага, 375.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

- Бараа материалын хандиваар хүлээн авсан 73.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг бараа материалын тайланд бусад хэсэгт тайлагнасныг аудитын явцад залруулж тайлагнуулсан.

- Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын 73.6 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 572.4 мянган төгрөгийг нэгтгэн 646.0 мянган төгрөгөөр тайлагнасныг эдийн засгийн ангиллаар тус тусад нь залруулж тайлагнуулсан.

4.3 Албан шаардлага

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд 570.6 мянган төгрөгийн нормын хувцас худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт



хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Бараа үйлчилгээний бусад зардлаас 375.0 мянган төгрөгийн тэмцээн уралдааны шагнал урамшуулал олгосон байна. Энэ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-д "210901-Бараа үйлчилгээний бусад зардал- Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагаатай холбоотой гарах бусад бараа үйлчилгээнд төлөх зардал буюу энэ ангилалд тусгайлан заагдаагүй боловч хууль, тогтоомж эрх зүйн бусад шийдвэрийн хүрээнд зөвшөөрөгдсөн, ажил үйлчилгээ үзүүлэгчид төлөх ёстой төлбөр хураамжууд энд хамаарна" гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	26 дугаар цэцэрлэг	4	1,665.2	2	719.6			1	570.6	1	375.0